



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн 2019 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан 17,818,411,860.4 (арван долоон тэрбум найман зуун арван найман сая дөрвөн зуун арван нэгэн мянга найман зуун жаран төгрөг дөчин мөнгө) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Цолмон нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000089



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн  
 .....56..... дугаар тогтоолын хавсралт



Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн 2019 онд  
 хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
		(мян.төгрөг)
<b>1.Барилга байгууламж</b>		
1	АШУҮИС-ийн Сургалтын цогцолборын 1200 оюутны байрны барилга угсралт /он дамжсан/	4,822,512.07
2	1200 оюутны байр, ажилчдын байрны гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралт	1,345,770.00
3	Спорт цогцолбор барилга угсралтын ажил	4,759,020.90
4	Номын сангийн барилга угсралтын ажил	1,955,320.82
5	Номын сан, Соёлын төв, Спорт төвийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралт	789,780.00
6	Цайны газрын барилга худалдан авах /Нүүр ам судлалын сургууль/	49,000.00
7	Дархан-Уул АУС-ийн хичээлийн өргөтгөлийн байр	259,240.26
8	А, Б блокийн гадна зам талбай, тохижилт, гадна гэрэлтүүлгийн ажил	309,029.95
9	Шинэ цогцолборын гадна хашааны ажил	303,600.00
<b>Бүгд дүн</b>		<b>14,593,274.00</b>
<b>2.Барилгын зураг төсөв</b>		
<b>2.1 Он дамжсан</b>		
10	Номын сангийн барилгын ажлын зураг, төсөв	32,677.27
11	Соёлын төвийн барилгын ажлын зураг, төсөв	54,119.94
12	Спорт цогцолбор барилгын ажлын зураг, төсөв	38,154.75
13	Эрдмийн өргөөний барилгын зураг, төсөв	45,000.00
14	32 ортой эрхэс сувиллын барилгын ажлын зураг	21,952.24
15	32 ортой эрхэс сувиллын гадна ажлын барилгын зураг төсөв	10,000.00
16	1200 оюутны байр, ажилчдын байрны гадна инженерийн шугам сүлжээний зураг, төсөв	28,000.00
17	Номын сан, Соёлын төв, Спорт төвийн гадна инженерийн шугам сүлжээний зураг, төсөв	45,000.00
<b>2.2 Шинэ зураг төсөв</b>		0
18	Ажилчдын байрны зураг төсөв	140,000.00
19	Хичээлийн нэгдүгээр байрны зураг төсөв	5,000.00
20	Өргөтгөлийн барилгын зураг төсөв /АШУҮИС-Дархан уул/	10,000.00



<b>Бүгд дүн</b>		<b>429,904.20</b>
<b>3. Их засвар</b>		
21	Барилга, байгууламжын засвар /АШУУИС-Төв/	438,508.21
22	Хичээлийн Б байрны гадна фасад хийх /АШУУИС-Дархан уул /	50,000.00
23	Хичээлийн нэгдүгээр байр, Оюутны дотуур байрны их засвар /АШУУИС-Дорноговь/	50,000.00
<b>Бүгд дүн</b>		<b>538,508.21</b>
<b>4. Тоног төхөөрөмж</b>		
24	Бага оврын автобус, 15 хүний суудалтай, хөдөлгүүрийн багтаамж 2.7 cc хүртэл, шинэ /АШУУИС-Төв/	84,000.00
25	Суудлын автомашин 5 хүний суудалтай, хөдөлгүүрийн багтаамж 2.5 cc хүртэл, шинэ /Дархан уул/	48,500.00
26	Бага оврын автобус 12 хүний суудалтай, хөдөлгүүрийн багтаамж 2.5 cc хүртэл, улсын дугаар аваагүй /Дорноговь/	20,000.00
27	Эмнэлэг лабораторийн тоног төхөөрөмж	591,382.95
28	Бусад тоног төхөөрөмж	52,552.50
29	Мэдээлэлийн технологийн хэрэгсэл	672,450.00
<b>Бүгд дүн</b>		<b>1,468,885.45</b>
<b>5. Тавилга эд хогшил</b>		
30	Тавилга эд хогшил	768,240.00
31	Иж бүрэн 5 ханатай гэр /АШУУИС-Дархан уул/	11,500.00
32	Контейнер-10 тн /АШУУИС-Дорноговь/	5,300.00
33	Хүлэмж /АШУУИС-Дорноговь/	2,800.00
<b>Бүгд дүн</b>		<b>787,840.00</b>
		<b>17,818,411.86</b>
<b>НИЙТ ДҮН</b>		(арван долоон тэрбум найман зуун арван найман сая дөрвөн зуун арван нэгэн мянга найман зуун жаран төгрөг дөчин мөнгө)

